


УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

ДАРГА



БАТЛАВ:

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН
ЯАМНЫ ТӨРИИН НАРИЙН БИЧГИЙН

Г.НАНДИНЖАРГАЛ

ШАТАХУУН НИЙЛҮҮЛЭХ НИЙЛҮҮЛЭГЧИЙГ СОНГОН
ШАЛГАРУУЛАХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

ХАРЬЦУУЛАЛТ

ДУГААР: УУХҮЯ/202012002

УЛААНБААТАР ХОТ
2020 ОН

НЭГ. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Огноо: 2020.02.12

Тендер шалгаруулалтын нэр: **Шатахуун нийлүүлэх**

Тендер шалгаруулалтын дугаар: УУХҮЯ/202012002

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам нь сонирхсон эрх бүхий тендерт оролцогчдоос шатахуун нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерт үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Энэхүү тендер нь Монгол Улсын цахим тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулагдаж байгаа тул тендерт оролцогч нь Цахим худалдан авах ажиллагааны систем www.tender.gov.mn-д өөрийн аж ахуйн нэгжийн хувийн нууцлалын кодоор нэвтрэн, тендерийн материалыаа электрон хэлбэрт /Adobe PDF/ шилжүүлж, цахим хэлбэрээр илгээнэ.

Тендерийн үнийн саналыг 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдөр 14:00 цагаас өмнө Төрийн цахим худалдан авах ажиллагааны системд цахимаар ирүүлнэ.

Нээлтэнд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 14:30 цагт Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 202 тоот өрөөнд тендерт оролцогчдын үнийн саналыг нээнэ.

Дотоодын давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд бусад мэдээллийг доорх хаягаар холбогдож тодруулна уу.

Монгол, Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо,
Нэгдсэн үндэстний гудамж, Засгийн газрын 2-р байр, 204

Утас: 51-260864, Факс: 318169

Имэйл хаяг: info@mmhi.gov.mn

Веб хаяг: <http://mmhi.gov.mn>

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- | | |
|---|---|
| <p>1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа</p> <p>2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт</p> <p>3. Тендерийн иж бүрдэл</p> <p>4. Тогтмол үнэ</p> <p>5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд</p> <p>6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа</p> <p>7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх</p> <p>8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл</p> | <p>1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.</p> <p>2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.</p> <p>2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.</p> <p>3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none">(а) Үнийн санал;(б) Нийлүүлэлтийн хуваарь;(в) Чадварын мэдээлэл /туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл; <p>4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.</p> <p>5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.</p> <p>5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.</p> <p>6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.</p> <p>7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.</p> <p>7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарыт заасан бараа нь ТШӨХ-д заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.</p> <p>7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.</p> <p>8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.</p> |
|---|---|

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТОӨЗ-НЫХОЛБОДОХ ЗААЛТ	Шалгуур үзүүлэлт
ТОӨЗ 1.1	<ul style="list-style-type: none"> • Унийн санал • Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар/ нотариатаар баталгаажуулсан/ • Татварын тодорхойлолт • Бүх харилцах банкны тодорхойлолт • Ижил төстэй бараа нийлүүлсэн туршлагын мэдээлэл /сүүлийн 3 жил буюу 2017, 2018, 2019 онуудын аль нэг жилд гүйцэтгэсэн ажлын гэрээ/ • Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо /2017, 2018, 2019/ • Гэрээний ерөнхий ба тусгай нөхцлийг зөвшөөрсөн мэдэгдэл • Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд: <ul style="list-style-type: none"> - Импортлох; - Бүх төрлийн шатахуун, шингэрүүлсэн шатдаг хийг импортлох - Жижиглэнгийн худалдаа эрхлэх - Бүх төрлийн шатахуун, шингэрүүлсэн шатдаг хийг түгээх станцаас худалдах үйл ажиллагаа; <p>Энэхүү тендер нь Монгол Улсын цахим тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулагдаж байгаа тул тендерт оролцогч нь Цахим худалдан авах ажиллагааны систем www.tender.gov.mn-д өөрийн аж ахуйн нэгжийн хувийн нууцлалын кодоор нэвтрэн, тендерийн материалыаа электрон хэлбэрт /Adobe PDF/ шилжүүлж, цахим хэлбэрээр илгээнэ.</p>
ТОӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: www.tender.gov.mn цахимаар авна.</p> <p>Огноо: 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдөр</p> <p>Цаг: 14 цаг 00 минут</p>
ТОӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Нэгдсэн үндэстний гудамж 5/2 Засгийн газрын II байр</p> <p>Давхар болон өрөөний дугаар: Хурлын заал 2 давхарт 202 тоот</p> <p>Огнос: 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдөр</p> <p>Цаг: 14 цаг 30 минут</p>
ТОӨЗ 4.1	Төгрөгөөр
ТОӨЗ 5.1	Нийлүүлэх бараа, үйлчилгээ нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа, үйлчилгээ нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зэрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
ТОӨЗ 5.2	Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
ТОӨЗ 6.1	Унийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

ТОӨЗ 6.2	Энэхүү тендер шалгаруулалтын барааны нэр: <ul style="list-style-type: none"> • АИ-92 бензин
ТОӨЗ 7.1	Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.

Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. Барааны тодорхойлолт:

- Нийлүүлэх шатахуун нь Монгол улсын MNS 0216: 2017, MNS 0217: 2017 стандартын шаардлагыг хангасан байх.
- Тендерийн шалгаруулалтанд оролцож байгаа байгууллагын шатахуун түгээх станц нь "Шатахуун түгээх станц. Техникийн шаардлага MNS 4628-2013 Монгол Улсын стандартын шаардлага хангасан байх.
- Нийлүүлэгч байгууллага нь шатахуун, шатах тослох материалын "Итгэмжлэгдсэн лаборатори"-той байх ба бүтээгдэхүүнүүд нь зохих хугацаанд шинжилгээнд хамрагдаж баталгаажсан байх.
- Шатахуун түгээгүүрийн газар нь 24 цагийн үйлчилгээтэй байх.

2. Стандарт: Монгол Улсын стандарт:

MNS 0216: 2017. Дизелийн түлш Евро.Техникийн шаардлага; MNS 0217: 2017. Хөдөлгүүрийн түлш. Этилжүүлээгүй бензин.

3. Бараа нийлүүлэлтийн хуваарь:

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

№	Нэр	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
1	AI-92 бензин		литр		Гэрээ байгуулсан өдрөөс		

ЖИШИГ МАЯГТ

Дөрөв. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга

танаа

- Бид, [төндерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
- Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
- Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Төндөрийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Төндөрт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамарагч.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Зургаа. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших	1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт	2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ.
3. Оюуны өмчийн эрх	3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах
4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх	4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.
5. Баталгаат засварын хугацаа	5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [1] жил байна.
6. Гэрээнд өөрчлөлт оруулах	6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.
7. Төлбөр	7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [ГТН-д заасан тоо] хоногийн дотор шуурхай хийнэ.
8. Бараа нийлүүлэх хуваарь	8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.
9. Алданги оногдуулах	9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.
10. Үүргээ Биелүүлээ гүйгээс гэрээг цуцлах	10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.
11. Маргааныг шийдвэрлэх	11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

Долоо. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- | | |
|---|--|
| <p>1. Шалгах болон турших (ГЕН – 1)</p> | <p>1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]</p> |
| <p>2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)</p> | <p>2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
2) барааг хүргэсэн тухай баримт, тэмэр замын болон тээврийн баримт;
3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
5) барааны гарал үүслийн гэрчилгээ.</p> |
| <p>Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.</p> | |
| <p>3. Баталгаат засвар (ГЕН-5)</p> | <p>5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
[Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]</p> |
| <p>4. Төлбөр (ГЕН – 7)</p> | <p>7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:

Гэрээний үнийн дүнгийн [too]¹ хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.</p> |
| <p>5. Алданги оногдуулах (ГЕН - 9)²</p> | <p>9.1. Алданги оногдуулах хувь: [0]
Алдангийн нийт дүн: [0]</p> |

¹ Ихэнх тохиолдолд 100 хувь байна. Шаардлагатай бол төлбөрийн хуваарийг өөрчилнө.

² Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

Найм. ГЭРЭЭНИЙ МАЯГТ³

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нэгөө талаас [нийлүүлэгчийн нэр] (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож оны _ сарын _ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

- Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
- Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “бараа” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсэээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
- Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
- Нийлүүлэгч нь _ оны _ дугаар сарын _ -наас _ оны _ дугаар сарын _ - нэр төрлийн барааг _ оны _ дугаар сарын _ -наас _ оны _ дугаар сарын _ - ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
- Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:
Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг⁴;
Үнийн санал;

³ Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

⁴ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний өрөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг]_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг]_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]